МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

М.Шагдарзав

Он сар өдөр, төрсөн газар	1914, Дундговь аймаг, Адаацаг сум
Үндсэн сүм хийд	Хорийн жас (Хорин жас, шинэ Дашчойнхорлин хийд)
Б.Ринченгийн сүм, хийдийн нэр	Зараа хорины хурал
Ярилцлаганд дурдагдсан бусад сүм хийдүүд	Чойрын хийд, Шинэ шавийн хийд

Дундговь аймаг, Адаацаг сум, Хорин жас

- **2007 оны 7 сарын 10-ны өдөр Дундговь аймгийн Мандалговь хотод Хорийн жасын тухай асуухаар өндөр настан М.Шагдарзав гуайтай ярилцаж байна. Хорийн жас хэдэн дугантай, хэдэн ламтай байсан бэ?**

Дөрвөн дугантай байсан. Зуугаад ламтай.

- **Ямар ямар дуган байсан бэ?**

Цогчин дуган, Хайлан дуган, Жүдийн дуган, Ламиран.

- **Хэдэн ламтай байсан бэ?**

Нийтдээ зуугаад ламтай байсан.

- **Хоёулаа бүдүүвч зураг зурвал чадах уу?**

За энд Цогчин дуган байхад, ард нь Сахиусын дуган, баруунтаа Хайлан, зүүн талд нь Жүд. Энд Ламиран байсан.

- **Энэ дугануудыг юуаар барьсан бэ?**

Хоёр нь модон, Сахиус, Жүд нь тоосгон дуган байсан.

- **Суварга байсан уу?**

Аа мэдэхгүй. Санахгүй байна, байсан байх.

- **Ямар овоо тахидаг байсан бэ?**

Тэр хойно нь Зараа уул гэж байсан, түүний Тахилгат овоо гэж байсан. Тэрнийг тахина.

- **Майдар эргэх үү?**

Үгүй, харин сор зална. Адаг сарын хорин есөнд сор зална.

- **Хийдийн гол сахиус ямар сахиус байсан?**

Жамсран улаан сахиус байсан.

- **Тэргүүн лам нь ямар лам байсан бэ?**

Миний нэг хамаатан ах Дамбадаржаа лам гэж байсан юм.

- **Та хэдэн настай байхдаа лам болсон бэ?**

Би нэг 5, 6-тай л байсан байх, мэдэхгүй.

- **Хэдэн ондоо лам байхаа больсон бэ?**

Арван найм, хорь хүртлээ л лам явсан.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

- **Та хэдэн онд төрсөн бэ?**

Би одоо 93-тай. Тэгэхээр хэдэн он болж байна.

- **Жас хэдэн онд хаагдсан бэ?**

1937, 1938 оны үед л байх.

- **Зоч лүйжин тавьдаг лам нар байсан уу?**

Тэнд чинь тийм юм байхгүй. Тэр чинь тусгай хүмүүс байсан. Цөөн хүмүүс байсан байх.

- **Төвдөөс Богдын хүрээнээс лам нар ирж байсан уу?**

Өө тийм юм байхгүй. Мэдэхгүй.

- **Хятадууд байсан уу?**

Өө ганц хоёр юм байсан. Энд тэнд угаасаа л ганц хоёр юм байдаг байсан. Бодвол шаварчин, худалдаачин хятад л байсан байх.

- **Жасын ойролцоо булаг шанд рашаан байсан уу?**

Байсан, Хадан усны рашаан гэж тэр ард нь байсан.

- **Шинэ Шавьтай ойрхон байсан уу?**

Ойрхон байсан, ойрхон байсан.Хорь гаруй л км байсан байх.

- **Шинэ жас дээр очиж байсан уу?**

Очиж байгаагүй ээ.

- **Тавин жас дээр очиж байсан уу?**

Бас тэнд очиж байгаагүй. Та нар яагаад энэ хавийн сүм хийдийг сайн мэдээд байна.

- **Бид нар монголын Төв Гандангийн лам нартай хамтарч судалгаа хийж байна. Та энэ Хорийн жасаас гадна өөр хийдэд сууж байсан уу?**

Чойрын хийдэд нэг, хоёр жил суусан. Нэг 20, 21 настай байсан юм болов уу. Гучин долоон онд л тэгээд бүрмөсөн хар болсон.

- **Чойрын хийд том хийд байсан биз?**

Өө, их том хийд байсан.

- **Тэнд цам гардаггүй байсан биз?**

Гардаггүй байсан. Зөвхөн Майдар эргэнэ.

- **Чойрт байхдаа аль дацанд сууж байв?**

Чойрын дацанд сууж байсан.

- **Чойрын гол шүтээн сахиус ямар сахиус байсан бэ?**

Өө яг үзсэн биш ямар сахиус байсныг санахгүй байна. Мэдэхгүй байна.

- **Заваа Дамдингийн тухай жаахан ярьж өгөхгүй юу?**

Аа, ерөнхий хүмүүсийн мэддэг түүхийг л мэднэ. Харин нэг домог хэлэхэд уг нь Заваа Дамдины эх нь Сүхбаатар аймгийн гаралтай хүн юм, Заваа Дамдинг гэдсэндээ байхад эх нь нутгаасаа гарч, Хүрээ орж Богдод мөргөхөөр ирж, Хүрээнд. Тэгээд Богдоос би нутаг буцах уу, хаана суурьших вэ гэтэл Богд чиний нутаг энэ өмнө зүгт байна, урагшаа яв гэжээ. Тэгээд давхар биетэй хүүхэн Хүрээнээс явж урагш явж байтал одоо энэ Бага газрын чулууны зүүн хойно Цагаан хийд гэдэг газар хүүхдээ төрүүлж, тэгээд Богдын өгсөн рашаанаар хүүхдээ угааж арц хүжээр ариутгасан юм гэнэ лээ. Тэр хүү нь хожмын Заваа Дамдин гавж байжээ.

- **За баярлалаа.**

Ярилцсан: М.Жужа, Т.Кристина, О.Энхбаяр

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон